

Боловсролын баримт бичигт хэвлэгдэх 262 нэрийг монгол бичигт хөрвүүлснийг зассан зарчим

Эдгээр нэрсийг Ш.Чоймаа нарын “Монгол хэлний хадмал толь”, Соёмбо принтинг, Улаанбаатар, 2011 толийг барьж заслаа. Цөөн гадаад үгийн бичлэгийг сүүл үед эрдэмтэн судлаачдын санал нэгдэн баримталж буй зарчмаар засаж бичлээ.

1. “Компьютер” гэдэг үгийг “ $\text{ᠬᠣᠮᠫᠦᠮᠦᠳᠡᠷ}$ ” гэж “п” болон “ю” үсгийн дунд шилбэтэй бичиж байсныг засаж “ $\text{ᠬᠣᠮᠫᠦᠮᠦᠳᠡᠷ}$ ” хэмээн бичлээ.
2. “Франц” улсын нэрийг “ $\text{ᠫᠷᠠᠨᠴ}$ ”, “ $\text{ᠫᠷᠠᠨᠴ}$ ”, “ $\text{ᠫᠷᠠᠨᠴ}$ ” гэхчлэн олон хувилбараар бичиж ирснээс “ $\text{ᠫᠷᠠᠨᠴ}$ ” хувилбарыг сонголоо.
3. “Электрон” гэдэг үгийг “ $\text{ᠡᠯᠡᠭᠡᠲᠷᠠᠨ}$ ” гэж бичлээ. Өмнө “э” үсэг үгийн эхэнд орвол “ $\text{ᠡ}$ ” гэж дан шүдээр, дунд, адагт орвол “ $\text{ᠡ}$ ” бичдэг байснаас татгалзаж үгийн эхэнд “ $\text{ᠡ}$ ”, дунд, адагт бусад эгшгийн адил титэмгүйгээр “ $\text{ᠡ}$ ” үсгээр бичих зарчимд судлаачид санал нэгдэж буй тул энэ зарчмаар бичив.